



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 4/96

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1. Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Хунан болон Монгол дахь Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн шадар суурин төлөөлөгч Аяако Кайно нар орон нутагт ажилласантай холбогдуулан хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд шаардагдсан 1,825,900 (нэг сая найман зуун хорин таван мянга есөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР